

БУМБЫН ШАШНЫ ДАРХАН УУЛ –У ДАН ШАНЬ

Т.СОДНОМЦОГ*

Бумбын шашин бол 1800 гаруй жилийн түүхтэй Хятадын уугуул шашин юм. Энэ шашны үйл ажиллагааг эрхэлж байгаа хүмүүсийг бумба гэж нэрлэх бөгөөд тэд судар ном уншихын зэрэгцээ зэвсгийн эрдэмд боловсрох сонирхолтой байдаг. Хятадын төв нутгийн Хубэй мужийн баруун хойд биед Бумбын шашны алдарт дархан уул У Дан шань уул бий. Хэдэн зуун жилд У Дан шань уул нь үзэсгэлэнт сайхан өндөр сүрлэг хайрхан болон бумбын шашны аугаа сүрлэг барилгатайгаараа дотоод гадаадад алдаршсан юм.

У Дан шань уулын тухайд Хятадын түүхэн дэх нэгэн алдарт хааныг дурьдахгүй байхын аргагүй. Тэр бол зургаан зуун жилийн өмнөх Мин улсын үеийн Юнь Лэ хаан болно. Хааны эрхт сүр хүчээ харуулахын тулд тэрбээр У Дан шань ууланд их барилга байгуулан, 300 мянга гаруй мужаан, дархан илгээж, арван хэдэн жилийн хугацаанд Бумбын шашны гуч гаруй томоохон барилга байгуулсан байна. Бумбын шашны эдгээр барилга нь Бээжин дэх хааны ордонтой адил бүр Мин улсын үеийн хааны барилга болох тул У Дан шань уулын барилгууд ч хад асганы ханан дахь хааны ордон болсон байна. 1994 онд У Дан шань уулыг ЮНЕСКО дэлхийн соёлын өвийн жагсаалтанд оруулжээ.

У Дан шань ууланд хүрээд мөргөлчдийн нарийхан зөрөг замаар уул руу мацан алтан оройт дуганд хүрч болно. Энэхүү алтан оройт дуган нь гөлгөр сайхан хаш суурин дээр байрладаг. Таван метр өндөр энэ дуган хэдийгээр зургаан зуу гаруй жилийн түүхтэй болсон хэдий ч алтан гэрэл цацарч гялалзан

харагдана. Алтан оройт дуганыг үнэндээ цул алтаар бүтээсэн биш, хүрлээр цутгаж алтаар өнгөлсөн юм байна. Энэ дуганыг 20 тонн цул гууль болон 300 кг алтаар бүтээсэн болохоор Хятадын хамгийн том гууль дуган гэж нэрлэж болно. Алтан дуганы индэр дор чин үнэнч сүсэгтэн нар мөргөл үйлдэж байдаг.

У Дан шань уул Бумбын бүх сүмтэй нэгэн адил энд бас У Дан шань уулын гол сахиусыг тахидаг. Энэ гол сахиус нь гээг үсээ сэгсийлгэсэн, хөл нүцгэн хүн мэт харагддаг.

Энэ сахиусын түүх нь: Тухайн үед алтан дээвэрт дуганыг байгуулж дуусаад дотор нь У Дан шань уулын гол сахиусын дүрийг бүтээх болсон байжээ. Жэн у да ди гэсэн гол сахиус чухам ямар төрхтэйг хэн ч мэдэхгүй, зарим уран дархан нь түүнийг тэнгэрийн сахиус шиг зурахад, зарим нь чөтгөр шиг зурсан гэдэг. Тэр нь хаан эзний санаанд таараагүйгээс олон хүнийг хөнөөсөн гэнэ. Хожим нэг уран дархан хаан эзний санааг ойлгож, хаанд бараалхахад хаан эзэн биеэ угааж байсан юм байх. Тэр дархан хаанд сөгдөн, би сахиусын хөлийг олж харлаа, харин нүүрийг нь хараагүй хэмээн айлтгасанд, Юнь Лэ хаан түүнд тэргүүнээ өргөөд хар гэжээ. Ингээд энэ уран дархан Юнь Лэ хааны дүр төрхөөр сахиусын дүр төрхийг урлан бүтээж, хөл нүцгэн бурхан сийлсэн гэдэг домогтой ажээ.

У Дан шань ууланд одоогоор бумбын шашинтан албан ёсоор зуу гаруй байна. Тэд өөр өөрийн ажилтай, зарим нь Бумбын хөгжим сурч, нэг хэсэг нь ном судлаж байхад нөгөө хэсэг нь зэвсгийн эрдэм сурдаг байна. У Дан шань бол түүх соёл байгалийн үзэмжийг хослуулсан уул юм.

* Д.Содномцог-МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн Хятад судлалын ангийн оюутан.